

Төсөл

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАМГААЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхдээ хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам”-ыг баримтална.

1.3.Аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасан хэлбэртэй байна.

Хоёр.Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ

2.1.Хохирогчийг бие махбод, сэтгэл зүйн дарамт, заналхийлэл, зүй бус бусад нөлөөлөл болон амь нас, эрүүл мэндэд аюул учруулах гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор түүнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлнэ.

2.2.Аюулын зэргийн үнэлгээ өндөр, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.4 дэх хэсэгт заасан нөхцөл байдал тогтоогдсон хүчирхийлэлд өртсөн хүүхэд, аюулын зэргийн үнэлгээ дунд боловч зайлшгүй түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх шаардлагатай хохирогчийг түр хамгаалах байранд байрлуулна.

2.3.Хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, хүүхдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд түүний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр түр хамгаалах байранд бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.

2.4.Түр хамгаалах байр нь хохирогчид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасан эмнэлгийн тусламж, сэтгэл зүйн, нийгмийн халамж, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцааг холбогдох байгууллагатай хамтран үзүүлэх арга хэмжээ авна.

2.5.Түр хамгаалах байр нь хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн эмэгтэй, ахмад настны онцлог, хэрэгцээ шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.6.Хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн эмэгтэй, ахмад настан нь байнгын асаргаа сувилгаа шаардлагатай, өөрийгөө бие даан асрах чадваргүй бол эмнэлэг, асрамжийн байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна.

2.7.Түр хамгаалах байранд байгаа хохирогчид гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангаж, түүний гэр бүлийн бусад гишүүдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалуулахаар гаргасан гомдол мэдээллийг нэн даруй шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

2.8.Түр хамгаалах байр нь Монгол Улсын үндэсний стандартад нийцсэн, үйл ажиллагааны дотоод журамтай байна.

2.9.Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гурав. Нэг цэгийн үйлчилгээ

3.1.Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх нэгж нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эмнэлгийн яаралтай тусламж, анхан шатны үзлэг, тайвшруулах болон сэтгэл зүйн зөвлөгөө, зааварчилгаа өгөх үйлчилгээг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш үзүүлнэ.

3.2.Аюулын зэргийн үнэлгээ дунд, бага тогтоогдсон, эсхүл эмнэлгийн тусламж үйлчилгээ зайлшгүй шаардлагатай хохирогчийг нэг цэгийн үйлчилгээнд хамруулна.

3.3.Нэг цэгийн үйлчилгээг үзүүлэхдээ хууль зүйн, эрүүл мэндийн, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан “Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам”, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Нэг цэгийн үйлчилгээний аюулгүй байдалд хяналт тавих журам”, Монгол Улсын үндэсний стандартыг тус тус баримтална.

Дөрөв. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнд хамруулах

4.1.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл учирсан бол Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авна.

4.2.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний журмыг баримтална.

4.3.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх, сэтгэл зүйн хамгаалалтад авах арга хэмжээг хамгаалалтад авсан эрх бүхий байгууллагаас Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлж болно.

4.4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 25.6, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33.6-д тус тус заасны дагуу албан тушаалтан, хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, ажилтнаас тавьсан шаардлагыг биелүүлэх, мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.

Тав. Хориглох зүйл

5.1.Түр хамгаалах байранд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35.7 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

5.2.Түр хамгаалах байрны ажилтан ажиллах хугацаандаа болон ажлаас чөлөөлөгдсөний дараа тус байрны байршил, хохирогчийн хувийн нууц, бусад нөхцөл байдлын талаарх мэдээллийг бусдад задруулах, мэдээлэхийг хориглоно.

5.3.Аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлж байгаа хохирогчтой хүнлэг бус харьцах, нэр төрийг нь гутаан доромжлох, ялгаварлан гадуурхахыг хориглоно.